

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ
ТОГТООХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 болон 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Хөгжлийн банк” гэх)-ны эрсдэл даах чадварт зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Хөгжлийн банк нь өөрийн үйл ажиллагаанд дараах зохистой харьцааг хангаж ажиллана. Үүнд:

- 1.2.1.Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа;
- 1.2.2.Тогтвортой санхүүжилтийн харьцаа;
- 1.2.3.Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа.

1.3.Хөгжлийн банк энэхүү журмын 1.2-т заасан зохистой харьцааны үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүнд үнэлгээ, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авна.

1.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Монголбанк Хөгжлийн банкны үйл ажиллагааны эрсдэлийг харгалзан энэхүү журмын 1.2-т зааснаас бусад нэмэлт зохистой харьцааг тогтоон, мөрдүүлж болно.

ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

2.1.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг тус банкны эрсдэл даах чадвартай өөрийн хөрөнгийг (цаашид “Өөрийн хөрөнгө” гэх) эрсдэлийн нэгдсэн үнэлгээтэй (цаашид “Эрсдэлээр жигнэсэн актив” гэх) харьцуулан тооцооно.

2.2.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ 9 хувиас багагүй байна.

2.3.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.3.1.Хувьцаа (энгийн болон давуу эрхийн);
- 2.3.2.Нэмж төлөгдсөн капитал (энгийн болон давуу эрхийн);
- 2.3.3.Хуримтлагдсан болон тайлант хугацааны ашиг, алдагдал;
- 2.3.4.Нөөцийн сан;
- 2.3.5.Хувьцаанд хөрвөх эх үүсвэр.

2.4.Дараах нөхцөлтэй давуу эрхийн хувьцааг өөрийн хөрөнгөд оруулан тооцно:

2.4.1.Хугацаагүй;
2.4.2.Хөгжлийн банк ногдол ашиг тогтмол төлөх үүрэггүй;
2.4.3.Ногдол ашгаас бусад хэлбэрээр өгөөжийн бүтэцгүй;
2.4.4.Энэ журмын 2.4.1-2.4.3-д заасан нөхцөлийг давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэр, холбогдох гэрээ, хэлцэлд тодорхой тусгасан байна.

2.5.Дараах нөхцөлийг хангасан эх үүсвэрийг хувьцаанд хөрвөх эх үүсвэрт тооцно:

2.5.1. 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай, нийт хугацаанд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;

2.5.2.Хугацааны эцэст Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч харилцан тохиролцож энгийн хувьцаанд хөрвөж болох нөхцөлтэй;

2.5.3.Хүү, өгөөж нь өсөн нэмэгдэхгүй (no step-up);

2.5.4.Эргэн төлөлтөд Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг баталгаа, батлан даалт гаргаагүй;

2.5.5.Хөгжлийн банкны хөрөнгө, активыг барьцаалаагүй;

2.5.6.Зөвхөн Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авсны дараа хугацаанаас нь өмнө төлж болох;

2.5.7.Энэ журмын 2.5.1-2.5.6-д заасан нөхцөлийг холбогдох гэрээ, хэлцэлд тодорхой тусгасан байна.

2.6.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоход дараах тохируулгыг хийнэ:

2.6.1.Халаасны хувьцааг өөрийн хөрөнгийн харгалзах төрлөөс хасна;

2.6.2.Гүүдвэлийг энгийн хувьцаанаас хасна;

2.6.3.Давуу эрхийн хувьцаа энгийн хувьцааны 50 хувиас илүүгүй байна;

2.6.4.Хувьцаанд хөрвөх эх үүсвэр нь энгийн хувьцааны 25 хувиас илүүгүй байна;

2.6.5.Санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийг нийт өөрийн хөрөнгийн дүнгээс хасна,

2.6.6.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 28 дугаар зүйлээр тогтоогдсон хязгаарлалтыг давсан хэсгийг нийт өөрийн хөрөнгийн дүнгээс хасна.

2.7.Монголбанк, эрх бүхий байгууллагын шаардлага, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана.

2.8.Хөгжлийн банкны эрсдэлээр жигнэсэн актив дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.8.1.Зээлийн эрсдэлээр жигнэсэн актив;

2.8.2.Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн актив;

2.8.3.Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив.

2.9.Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргүүдийн харгалзах эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална.

2.9.1.Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.9.1.1.Актив нь энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан нэгээс олон ангилалд хамаарч байгаа бол хамгийн өндөр эрсдэлийн жинтэй ангилалд хамааруулна;

2.9.1.2.Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон зээлжих суурь (baseline)¹зэрэглэлийг ашиглан гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээг дараах хүснэгтийг үндэслэн тогтооно.

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
3 сараас дээш хугацаатай авлага	20%	50%	50%	100%	150%	100%
3 сар хүртэл хугацаатай авлага	20%	20%	20%	50%	150%	100%

2.9.2.Энэ журмын 2.9.1.2-т заасан 2 болон түүнээс дээш зэрэглэл тогтоох байгууллагаас зээлжих зэрэглэл тогтоолгосон гадаадын банкнаас авах авлага болон түүний батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг тооцохдоо хамгийн доод зэрэглэлийг ашиглана.

2.10.Эрсдэлээр жигнэх тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын үлдэгдэлд дараах тохируулгыг хийнэ:

2.10.1.Актив нь Олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол холбогдох дүнгийн 80 хувиар цэвэршүүлнэ;

2.10.2.Актив нь Монгол Улсын Засгийн газрын баталгаатай, Монгол Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй, тэр нь холбогдох гэрээ, хэлцлээр батлагдаж байгаа бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;

2.10.3.Актив нь Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол холбогдох дүнгээр цэвэршүүлнэ;

2.10.4.Төгрөгөөр эргэн төлөгдөх актив нь дотоодын банкны баталгаа, батлан даалтаар баталгаажсан бол холбогдох дүнгийн 50 хувиар цэвэршүүлнэ;

2.10.5.Тухайн активд зориулж тусгайлан байгуулсан сангаар цэвэршүүлнэ;

2.10.6.Актив нь үл маргах журмаар цэвэршүүлэх нөхцөлтэй актив хариуцагчаас Хөгжлийн банканд байршуулсан актив хариуцагчийн санхүүгийн эх үүсвэр болон сорьцоор баталгаажсан алт, мөнгөн гулдмайгаар баталгаажсан бол харгалзах (спот) дүнгээр цэвэршүүлнэ.

¹ Baseline үнэлгээгүй тохиолдолд хамгийн Long term үнэлгээг авна.

2.11.Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын нийлбэрээс зээлийн эрсдэлтэй холбоотой бусад эрсдэлийн сангийн нийлбэрийг хасна.

2.12.Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активыг энэ журмын 4.2-т тусгасан нийт нээлттэй позицийн дүнгээр тодорхойлно.

2.13.Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив нь сүүлийн гурван жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг тус банкны мөрдөж байгаа өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн тогтооно.

2.14.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл даах чадварыг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

ГУРАВ. ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХАРЬЦАА

3.1.Хөгжлийн банк актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор тогтвортой санхүүжилтийн харьцааг мөрдөнө.

3.2.Тогтвортой санхүүжилтийн харьцааг энэ журмын 3.4-т тодорхойлсон тогтвортой эх үүсвэрийг энэ журмын 3.5-т тодорхойлогдсон урт хугацаат хөрөнгө оруулалтад харьцуулан 2 дугаар хавсралтын дагуу тооцно.

3.3.Хөгжлийн банкны тогтвортой санхүүжилтийн харьцаа 100 хувиас багагүй байна.

3.4.Хөгжлийн банкны тогтвортой эх үүсвэр дараах бүрэлдэхүүнтэй байна.

3.4.1.Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө;

3.4.2.Энэ журмын 2.5-д тусгасан шаардлагыг хангасан эх үүсвэрийн үлдэгдэл;

3.4.3.Санхүүгийн бус байгууллагаас татсан харилцах, хадгаламжийн үлдэгдэл;

3.4.4.Нэгээс дээш жилийн хугацаанд (remaining maturity) эргэн төлөгдөх банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн үлдэгдэл;

3.4.5.Нэгээс дээш жилийн хугацаанд (remaining maturity) эргэн төлөгдөх бусад эх үүсвэрийн үлдэгдэл.

3.5.Хөгжлийн банкны урт хугацаат хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна.

3.5.1.Нэгээс дээш жилийн хугацаанд эргэн төлөгдөх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);

3.5.2.Нэгээс доош жилийн хугацаанд эргэн төлөгдөх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдлийн 50 хувь (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);

3.5.3.Чанаргүй зээлийн үлдэгдэл (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);

3.5.4.Хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, вексель, өрийн бичгийн үлдэгдэл;

3.5.4.1.Тухайн актив эсвэл төлбөр хариуцагч нь олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А” ба түүнээс дээш үнэлгээтэй бол 80 хувиар цэвэршүүлнэ.

3.5.5.Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл;

3.5.6.Өмчлөх бусад хөрөнгийн үлдэгдэл;

3.5.7.Үндсэн хөрөнгө;

3.5.8. Ирэх 2 жилийн хугацаанд хэрэгжих цэвэр хүлээж болох үүргийн 50 хувь.

3.6.Хөгжлийн банкны өөрийн төлбөрийн чадварыг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

ДӨРӨВ. ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦ

4.1.Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг Хөгжлийн банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор гадаад валютын нийт нээлттэй позицид хязгаарлалт тогтооно.

4.2.Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрт тооцсон урт позицуудын нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр цэвэршүүлсэн алт, мөнгөний нээлттэй позицийн абсолют дүнг нэмж тодорхойлох бөгөөд Хөгжлийн банкны энэ журмын 2.6-д заасан тохируулгыг 2.3-т тусгасан өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй.

4.3.Нэг гадаад валютын нээлттэй позицийг дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцож биелэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу сар бүр ирүүлнэ:

4.3.1.Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассив, эх үүсвэрийн зөрүү (үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан, цэвэршүүлсэн алт, мөнгөн гулдмайны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана, активын дүнгээс өөр валютаар сан байгуулсан валютын чанаргүй активыг хасна);

4.3.2.Гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой авлага, өглөгийн зөрүү (үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасаж тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг ирээдүйн ханшаар нь үнэлж болно);

4.3.3.Тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн сөрөг дүн. Ингэхдээ дараах тохируулгыг хийнэ.

4.3.3.1.Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн ижил валютаарх эх үүсвэр нь тухайн банканд байршсан бол тэдгээрийг хасна;

4.3.3.2.Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүрэг нь тухайн банканд ижил валютаар зээлийн шугамтай бол тэдгээрийг хасна;

4.3.4.Гадаад валютаар гаргасан бусад үүргийн сөрөг дүн;

4.3.5.Бусад үүрэг, гэрээ, хэлцлээр баталгаажсан гадаад валютын орлого, зарлагын зөрүү.

4.4.Монголбанк биелэгдэх боломжгүй гэж үзсэн гадаад валютын ирээдүйн өглөг, авлагыг нээлттэй позицийн тооцоонд оруулахгүй байж болно.

4.5.Хөгжлийн банкны ханшийн эрсдэлээс үүсэх алдагдлыг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

ТАВ. БУСАД ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

5.1.Хөгжлийн банк эрсдэлийг удирдах зорилгоор дараах зохистой харьцааг дотооддоо тогтоон мөрдүүлнэ:

5.1.1.Эдийн засгийн нэг салбарт олгох зээл, зээлтэй адилтган тооцох активын нийлбэр, нийт зээл, зээлтэй адилтган тооцох активын харьцаа.

5.2.Энэхүү журмын 5.1-д заасан зохистой харьцааг тооцох аргачлал, мөрдөн ажиллах зохицуулалт нь олон улсын туршлагад нийцтэй байна. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хөгжлийн банк өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тулгуурлан тогтооно.

5.3.Энэхүү журмын 5.1-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон тооцох аргачлалд өөрчлөлт оруулах тухай бүр Монголбанканд мэдэгдэнэ.

5.4.Хөгжлийн банк дотооддоо мөрдүүлэх үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтүүд нь энэ журмын 5.1-ээр хязгаарлагдахгүй.

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ

6.1.Хөгжлийн банкны нийт зээлийн багцын хэмжээг хуульд заасан хязгаарлалтын дотор Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

6.2.Хөгжлийн банк нь нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох активын нийлбэр нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтэрсэн бол түүнийг том зээлдэгч гэж үзнэ.

6.3.Нийт том зээлдэгч, тэдгээрт холбогдогч этгээдүүдэд олгосон зээл, зээлтэй адилтгах хөрөнгийн дүн нь Хөгжлийн банкны нийт зээл, зээлтэй адилтгах активын нийлбэр дүнгийн 80 хувиас хэтрэхгүй байна.

6.4.Хамгийн өндөр эрсдэлийн сан байгуулсан 40 зээл, зээлтэй адилтгах активын тайланг дөрөвдүгээр хавсралтын дагуу сар бүр хүргүүлнэ.

ДОЛОО. БУСАД

7.1.Хөгжлийн банк энэ журамд тусгасан зохистой харьцааг өдөр бүр хангаж ажиллана. Энэ журамд тусгасан зохистой харьцааг алдагдсан тохиолдолд Монголбанканд болон Санхүүгийн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр, банк хариуцсан хянан шалгагчид (багийн ахлагчид) цахим шуудангаар тухай бүр мэдэгдэнэ.

7.2.Хөгжлийн банк зохистой харьцааны биелэлтийн болон Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанканд болон Санхүүгийн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр болон цахим системээр ирүүлнэ. Тайлан хүлээн авч, хянасан тухай албан бичгийг Монголбанкнаас Хөгжлийн банк болон Санхүүгийн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж болно.

7.3.Энэ журмын хэрэгжилтэд Монголбанк хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ авна.

Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааны
зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон
үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох,
түүнд хяналт тавих журмын 1 дүгээр хавсралт

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Огноо	ҮЗҮҮЛЭЛТ	Сая төгрөгөөр
№		Дүн
A	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
1	Энгийн хувьцаа	
2	Нэмж төлөгдсөн капитал (энгийн хувьцаа)	
3	Давуу эрхийн хувьцаа	
4	Нэмж төлөгдсөн капитал (давуу эрхийн)	
6	Хуримтлагдсан ашиг, алдагдал	
5	Нөөц сан	
6	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр	
7	Тохируулга	
B	ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ДҮН	Эрсдэлийн жин (%)
I	Тэнцлийн дүн	
1	Бэлэн мөнгө	0%
2	Замд яваа мөнгө	20%
3	Монгол Улсын Төв банкнаас авах авлага, түүнд хуримтлуулсан хүү	0%
4	Дотоодын банкнаас авах авлага /3 сараас доош хугацаатай, төгрөг/	20%
5	Дотоодын банкнаас авах бусад авлага	100%
6	Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас авах авлага	100%
7	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	xxxxx
7.1	3 сараас дээш хугацаатай	xxxxx
7.1.1	AA- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%
7.1.2	BBB-; A+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
7.1.3	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	100%
7.1.4	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
7.2	3 сараас доош хугацаатай	xxxxx
7.2.1	BBB- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%
7.2.2	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
7.2.3	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
7.4	Үнэлгээгүй гадаадын санхүүгийн байгууллага	100%
8	Монгол Улсын Төв банкны үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
9	Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
10	Дотоодын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	100%
11	Гадаадын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	100%
11.1	3 сараас дээш хугацаатай	xxxxx
11.1.1	AA- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	20%
11.1.2	BBB-; A+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	50%
11.1.3	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	100%

11.1.4	В- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	150%
11.2	3 сараас доош хугацаатай	×××××
11.2.1	BBB- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	20%
11.2.3	В-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	50%
11.2.4	В- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллагын	150%
11.2.5	Үнэлгээгүй гадаадын санхүүгийн байгууллагын	100%
12	Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	100%
13	Зээл	×××××
13.1	Чанаргүй зээл	150%
13.2	Ханшийн эрсдэлтэй этгээдэд олгосон гадаад валютын зээл*	150%
13.3	Бусад зээл	100%
14	Санхүүгийн хөрөнгө, хуримтлагдсан хүү	100%
15	Санхүүгийн бус хөрөнгө	×××××
15.1	Алт, мөнгөн гулдмай	0%
15.2	Бусад санхүүгийн бус хөрөнгө	100%
16	Үндсэн хөрөнгө, Хөр.Ор.Зор.Үл.Хөд.Хөр, Бор.Зор.хөрөнгө	100%
17	Дериватив санхүүгийн хөрөнгө	×××××
17.1	Монголбанктай хийсэн	0%
17.2	Бусад	×××××
17.2.1	AA- дээш үнэлгээтэй этгээтэй хийсэн бол	20%
17.2.2	BBB-; A+ үнэлгээтэй этгээтэй хийсэн бол	50%
17.2.3	В-; BB+ үнэлгээтэй этгээтэй хийсэн бол	100%
17.2.4	В- бага үнэлгээтэй этгээтэй хийсэн бол	150%
II	Тэнцлийн гадуурх дансны дүн	×××××
1	Аккредитив	20%
2	Ирэх 2 жилд хэрэгжих батлан даалт, баталгаа	50%
3	Тендер болон гүйцэтгэлийн баталгаа, батлан даалт	50%
4	Зээлийн шугам	50%
5	Хамтын санхүүжилттэй зээлийн эрсдэлд харгалзах зээлийн цэвэр үлдэгдэл	100%
6	Бусад хүлээж болох үүрэг	100%
III	Гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлт	
IV	Сүүлийн гурван жилийн эерэг ашгийн дундаж	
Г	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (А/Б*100%)	

Энэхүү тайланд активыг хугацаагаар нь ангилах бол үлдсэн хугацааг нь ашиглана.

“-Зээл, үнэт цаас, эдгээртэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд холбогдох гадаад валютаар төлөх нийт төлбөрийн дүн нь сүүлийн 2 жилийн нийт гадаад валютаарх орлогын дунджийн 85 хувиас их этгээдийг ханшийн эрсдэлтэй гэж үзнэ. Уг этгээд нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банктай ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зээлийн нийт хугацаанд байгуулсан бол ханшийн эрсдэлгүй гэж тооцно.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааны
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон,
 үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох,
 түүнд хяналт тавих журмын 2 дугаар хавсралт

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТЫН ХАРЬЦАА

Огноо	Сая төгрөгөөр
№	Үзүүлэлт
А	Тогтвортой эх үүсвэр
1	Хөгжлийн банкны өөрийн хөрөнгө;
2	Энэ журмын 2.5-д тусгасан шаардлагыг хангасан эх үүсвэрийн үлдэгдэл;
3	Харилцах, хадгаламжийн үлдэгдэл;
4	Нэгээс дээш жилийн хугацаанд (үлдэх хугацаагаар) эргэн төлөгдөх банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн үлдэгдэл;
5	Нэгээс дээш жилийн хугацаанд (үлдэх хугацаагаар) эргэн төлөгдөх бусад эх үүсвэрийн үлдэгдэл.
Б	Урт хугацаат хөрөнгө оруулалт
1	Нэгээс дээш жилийн хугацаанд эргэн төлөгдөх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);
2	Нэгээс доош жилийн хугацаанд эргэн төлөгдөх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн үлдэгдлийн 50 хувь (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);
3	Чанаргүй зээл (эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн);
4	Хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, вексель, өрийн бичгийн үлдэгдэл;
5	Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл;
6	Өмчлөх бусад хөрөнгө;
7	Үндсэн хөрөнгө;
8	Ирэх 2 жилийн хугацаанд хэрэгжих цэвэр хүлээж болох үүргийн 50 хувь.
В	ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХАРЬЦАА А/Б
Г	БАЙВАЛ ЗОХИХ ХЭМЖЭЭ
Д	НЭМЭЛТ ШААРДЛАГАТАЙ АКТИВЫН ХЭМЖЭЭ (Г-В)*Б
	≥100%

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүү, бүртгэлийн газрын захирал

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

/нэр/

/нэр/

Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааны
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон
 үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох,
 түүнд хяналт тавих журмын 3 дугаар хавсралт

ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦИЙН ТАЙЛАН

Огноо

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж валют (Мянган нэгжээр)								Банкнаас оруулсан	ТЭНЦЛИЙН ДҮН	
		USD	EUR	JPY	GBP	CNY	KRW	CHF	Бусад /USD/		USD (Сая.\$)	MNT (сая.₮)
A	ГАДААД ВАЛЮТЫН АКТИВ											
	Мөнгөн хөрөнгө											
	Хөрөнгө оруулалт (цэвэр)											
	Зээлийн өрийн үлдэгдэл (цэвэр)											
	Бусад хөрөнгө											
	Арилжаа (Дериватив санхүүгийн хөрөнгө)											
B	ГАДААД ВАЛЮТЫН ПАССИВ											
	Харилцах											
	Хадгаламж											
	Банк, СБ-с татсан эх үүсвэр											
	Бусад эх үүсвэр											
	Бусад өр төлбөр											
	Арилжаа (дериватив санхүүгийн өглөг)											
C	ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС											
	Баталгаа											
	Батлан даалт											
	Аккредитив											
	Бусад хүлээж болзошгүй үүрэг											
D	ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦИ											
E	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Саяаар, тухайн валютаар)											

F	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (НЭГЖ ВАЛЮТААР)											
G	УРТ ПОЗИЦ (Тэрбум төгрөгөөр)											
H	БОГИНО ПОЗИЦ (Тэрбум төгрөгөөр)											
I	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (НИЙТ)											
J	ХАМГИЙН ИХ ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ											
K	ХАМГИЙН ИХ ЭРСДЭЛ БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА											
	Ханш											

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүү, бүртгэлийн газрын захирал

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

/нэр/

/нэр/

Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааны
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон
 үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох,
 түүнд хяналт тавих журмын 4 дүгээр хавсралт

ХАМГИЙН ӨНДӨР ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛСАН 40 ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Огноо										Сая төгрөгөөр										
#	Дансны дугаар	Нэр	Регистрийн дугаар	Олгосон зээлийн хэмжээ	Зээл олгосон огноо	Зээлийн хамгийн сүүлд хийгдсэн төлөлтийн		Үүнээс:		Тайланг үеийн зээлийн үлдэгдэл	Үүнээс:		Тайланг үеийн зээлийн ангилал	Тайланг үеийн зээлд байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээ	Өмнөх тайлангийн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ	Зээл олгох үеийн барьцаа хөрөнгийн үнэлгээ	Тайланг үеийн барьцаа хөрөнгийн үнэлгээ	Хамгийн сүүлд барьцаа хөрөнгөд хийсэн үнэлгээний огноо	Зээл олгосон валют	
						Огноо	Хэмжээ	Үндсэн зээлийн төлбөр	Хүүгийн төлбөр		Үндсэн төлбөрийн үлдэгдэл	Хүүгийн төлбөрийн үлдэгдэл								
1																				

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

Санхүү, бүртгэлийн газрын захирал

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

/нэр/

/нэр/